



X-XII/2021

Тархаасан: 2022 оны 01 дүгээр сарын 14



Ажил эрхэлж буй гадаадын иргэд өмнөх улирлаас 2.4 хувиар буурчээ


Манай улсад 2021 оны 4 дүгээр улирлын эцэст гадаадын 77 улсын 5.6 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна. Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх улирлаас 136 (2.4%) хүнээр буурсан байна.

Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 5.0 (90.0%) мянга нь эрэгтэй, 0.6 (10.0%) мянга нь эмэгтэй байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй нийт гадаадын иргэдийн 62.9 хувь нь БНХАУ-ын, 4.8 хувь нь ОХУ-ын, 4.2 хувь нь Вьетнам Улсын, 3.9 хувь нь БНСУ-ын, 2.9 хувь нь БНЭУ-ын, 2.4 хувь нь Австрали Улсын, 2.3 хувь нь Албани Улсын, 2.0 хувь нь АНУ-ын, 14.6 хувь нь бусад улсын харьяат байна.

Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 17.9 хувь нь 50-54 насныхан, 17.6 хувь нь 45-49 насныхан, 14.6 хувь нь 35-39 насныхан байгаа бол 1.6 хувь нь 24 хүртэлх насныхан байна.

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2.1 (38.2%) мянга нь Улаанбаатарт, 2.0 (36.3%) мянга нь Төвийн бүсэд, 1.0 (17.3%) мянга нь Зүүн бүсэд, 0.3 (4.7%) мянга нь Баруун бүсэд, 0.2 (3.5%) мянга нь Хангайн бүсэд ажиллаж байна.

ЗУРАГ 1. АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ГАДААДЫН ИРГЭД, насны бүлгээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар



Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2.2 (38.3%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 2.0 (36.4%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 0.8 (14.9%) мянга нь бүрэн дунд, 0.4 (7.1%) мянга нь тусгай мэргэжлийн дунд, 0.2 (3.3%) мянга нь суурь боловсролтой байна.


Ажил эрхэлдэг гадаадын иргэдийн хамгийн их буюу 2.5 (44.8%) мянга нь мэргэжилтэн, хамгийн бага буюу 2 (0.1%) иргэн хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтнаар ажиллаж байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар



Манай улсад 2021 оны 4 дүгээр улиралд ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 2027 (36.1%) нь уул уурхай, олборлолтын, 1600 (28.5%) нь барилгын, 494 (8.8%) нь боловсролын, 377 (6.7%) нь боловсруулах үйлдвэрлэлийн, 344 (6.1%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 219 (3.9%) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 79 (1.4%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, 75 (1.3%) нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны, 402 (7.2%) нь бусад салбарт ажиллаж байна. Өмнөх улиралтай харьцуулахад, тухайлбал уул уурхайн олборлолтын салбарт ажил эрхэлж буй гадаадын иргэд 418 (26.0%) хүнээр өсөж, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбарт 224 (50.6%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар, улирлаар



Байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 5.0 (88.9%) мянга нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 0.3 (5.9%) мянга нь төрийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газарт, 0.2 (2.9%) мянга нь төрийн бус байгууллагад, 0.1 (2.3%) мянга нь бусад байгууллагад ажиллаж байна.

Ойлголт, тодорхойлолт

- Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.
- Гадаад иргэдэд ажил эрхлэх үйлчилгээг “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах” тухай хууль, Засгийн газраас тухай бүр батлан гаргадаг гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой тогтоол шийдвэрийн хүрээнд үзүүлдэг. “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 15.1.4, 8, 9-р заалтын дагуу “HG”, “O” болон “SH” ангиллын визээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ болон уригч талын хөдөлмөрийн гэрээгээр ирсэн гадаадын иргэдэд ажил эрхлэх зөвшөөрөл олгож байна.
 - ❖ “HG” ангиллын визээр цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээгээр ирж ажиллана.
 - ❖ “SH” ангиллын визээр шашны байгууллагын урилгаар (i) цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид, (ii) цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.
 - ❖ “O” ангиллын визээр төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын урилгаар цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.



Эх үүсвэр:

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Нийгмийн статистикийн газрын
Өрхөд суурилсан судалгааны хэлтэс
статистикч Б.Лхагвасайхан
Утас : (976-51)-265543

Нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

